БАТЛАВ. УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ

20 18 оны 01 сарын 10 өдөр Улаанбаатар хот

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн шаардлага

- Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт болон Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандартыг (СТОУС болон НББОУС) судалж, практикт нэвтрүүлэх
- Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 16.1, 17.2, 19.1.1 заалтуудыг хэрэгжүүлэх
- Нягтлан бодох бүртгэл хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх талаар Дэлхийн банк болон бусад донороос өгсөн зөвлөмжийн баримт бичиг
- Нягтлан бодох бүртгэл, санхүү, эдийн засгийн тэргүүний ажилтны улсын III,IV,V зөвлөгөөнөөс гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх
- Төрийн аудит болон санхүүгийн хяналтын байгууллага зөвлөмж

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын зорилго

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын зорилго нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн журам, зааврын дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, санхүүгийн тайлан, сайдын багцын нэгтгэсэн тайлан бэлтгэхэд хэрэглэх зарчим, горимыг тогтоож өгөхөд оршино.

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн хамрах хүрээ, үйлчлэх хугацаа

Энэхүү баримт бичгийг Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдын яамны аппарат, хөрөнгө оруулалт, Геологи судалгааны ажлын бүртгэл хөтлөх, санхүүгийн тайланг бэлтгэх болон сайдын багцын нэгтгэл хийх, нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх үйл явцыг гүйцэтгэхэд мөрдөнө.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны талаар харилцагч, хэрэглэгч нарт толилуулж байгаа албан ёсны мэдээлэл, санхүүгийн тайлан, тэдгээрийн хавсралт, тодруулга нь энэхүү бодлогын шаардлагад нийцсэн байна.

Бүртгэлийн бодлогын баримт бичгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 2018 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын агуулга

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын тухай "УСНББОУС-8"-д: "Нягтлан бодох бүртгэлийн бодлого гэдэг нь санхүүгийн тайланг бэлтгэх болон толилуулахад мөрддөг аж ахуйн нэгжийн гаргасан тусгай зарчим , суурь , дүрэм, журам ба практик үйл ажиллагаа юм. " гэж тодорхойлсон.

Энэ агуулгын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманы нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөх дараах зүйлд анхаарал хандуулна.

1. Яамны үйл ажиллагаанд мөрдөх мөрдөх бүртгэлийн зарчмуудыг тогтоож өгөх
2. Яамны санхүүгийн тайланг аккруэл сууриар бэлтгэх
3. Яамны үйл ажиллгаанд мөрдөх бизнесийн хуулиуд болон СТОУС-ын хэргэлээг тогтоох
4. Яамны үйл ажиллагаанд мөрдөж байгаа бүх дүрмийг судалж нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй уялдуулах
5. Яамны үйл ажиллагаанд мөрдөж байгаа бүх дүрмийг судалж шаардлагатай бол нэмэлт сайжруулалт хийх
6. Яамны бүртгэлийн үйл ажиллагааг газар дээр нь судалж холбогдох мэргэжилтэн нартай уулзаж компанийн онцлогт тохирсон практик хэрэглээнд (хүлээн зөвшөөрөх, уулын үйлдвэрийн зардал бүртгэж өртөг тооцох, элэгдэл тооцох, хөрөнгийг капиталжуулах, бодит үнэ цэнэ тогтоох, найдваргүй авлагын хасалдуулга тооцох, татварын зөрүүгийн тооцоо хийх, валютын ханшийн өөрчлөлт тооцох гэх мэт) анхаарч нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгана.

5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, гормын бүтэц

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн ерөнхий бүтэц, зохион байгуулалт дараах байдалтай байна. Үүнд :

Нэг. Үндсэн ойлголт

Хоёр. Нягтлан бодох бүртгэлийн зохион байгуулалт

Гурав. Нягтлан бодох бүртгэлийн ерөнхий бодлого

Дөрөв. Нягтлан бодох бүртгэлийн тусгай бодлого, горимууд

Тав. Хавсралт

6. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад ашиглах материал

Нэг. Монгол улсын хуулиуд

1. Төсвийн тухай хууль
2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
4. Төрийн албаны тухай хууль
5. Хөдөлмөрийн тухай хууль
6. Архивын тухай хууль
7. Эрдэс баялгийн тухай хууль
8. Татварын багц хуулиуд
9. Нийгмийн даатгалын багц хуулиуд
10. Үнэт цаасны тухай хууль
11. Татварын багц хууль
12. Концессын тухай хууль
13. Төрийн хяналт шалгалтын тухай хууль
14. Аудитын тухай хууль

Хоёр. Монгол улсын засгийн газрын тогтоолууд

1. Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн дүрэм /Монгол Улсын 2012 оны 32 дугаар тогтоол /
2. Дотоод аудитын дүрэм батлах тухай /Монгол Улсын 2012 оны 129 дугаар тогтоол /
3. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам /Монгол Улсын 2001 оны 134 дүгээр тогтоол /
4. Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам /Монгол Улсын 2005 оны 233 дугаар тогтоол/
5. Мэргэшсэн нягтлан бодогчдод нэмэгдэл олгох тухай /Монгол Улсын 2002 оны 174 дүгээр тогтоол /

6. Босго үнэ шинэчлэн батлах тухай /Монгол Улсын 2013 оны 68 дугаар тогтоол /

Гурав. Анхан шатны бүртгэлийн маягтууд

1. "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар /Санхүү, эдийн засгийн сайд, ҮСГ-ын даргын 2002 оны 171/111 дүгээр хамтарсан тушаал/

Дөрөв. НББ-ийн журнал, хураангуй ба дэлгэрэнгүй бүртгэл

1. Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягт, түүнийг хөтлөх аргачлал /Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 191 дүгээр тушаал /

Тав. Монгол улсын сангийн сайдын тушаалаар батлагдсан заавар, журам

1. Санхүү, эдийн засгийн сайдын 2000 оны 116 тоот тушаалаар баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт, дансны үлгэрчилсэн заавар",

2. Сангийн сайдын 2012 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 77 тоот тушаалаар баталсан "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан тодруулга бэлтгэх заавар"

3. Аж ахуйн нэгж, байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, горим.

4. Сангийн сайдын 2002 оны 133 дугаар тушаалаар "Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланд шинжилгээ" хийх үлгэрчилсэн заавар

5. Сангийн сайдын 2011 оны 12 дугаар тушаалаар "Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын зардлыг нягтлан бодох бүртгэлд бүртгэх журам"

6. Сангийн сайдын 2010 оны 121 дугаар тушаалаар "Аж ахуйн нэгжийн санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам"

7. Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн бүртгэлийн заавар /Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 401 дүгээр тушаал /

8. Эд хариуцагчийн эрх үүргийн дүрэм /Санхүү, эдийн засгийн сайдын 2000 оны 69 дүгээр тушаал /

9. Мэргэшсэн нягтлан бодогчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам /Санхүү, эдийн засгийн сайдын 258 дугаар тушаал /

10. Төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнах журам /Сангийн сайдын 2006 оны 192 дугаар тушаал /

11. Албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай /Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаал/

12. Гадаад албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай /Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаал/

13. Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авах, хянах, нэгтгэл хийх журам /Сангийн сайдын 2012 оны 83 дугаар тушаал /

14. Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжид хяналт тавих журам /Сангийн сайдын 2009 оны 252 дугаар тушаал /

15. Дотоод аудит явуулах заавар / Сангийн сайдын 2010 оны 116 дугаар тушаал/

16. Төсвийн байгууллагад мөрдөгдөх кассын ажиллагааны журам / Сангийн сайдын 2012 оны 216 дугаар тушаал/

17. Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуурын журам / Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаал/

Зургаа. Бусад дүрэм, журам, норм, норматив

1. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай / Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны хурлын 2013 оны 07 тоот тогтоол /

2. Дундаж цалин хөлс тодорхойлох журам / Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 тоот тушаал/

3. Ээлжийн амралт олгох заавар, журам /Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаал/

4. Жишиг норм батлах тухай / Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 тоот тушаал/

5. Бусад тогтоол шийдвэр

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргааны

удирдлагын газрын санхүүгийн хэлтсийн дарга Б.Уужим-Ухаан

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргааны

удирдлагын газрын санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн М.Нямсүрэн